

ЕВРАЗИЙН ОРОН ЗАЙД НОЁРХОХ ОРОС, ХЯТАДЫН БОДЛОГО: МОНГОЛ УЛСЫН АНХААРАХ АСУУДАЛ


В.Ариунчимэг

МҮОНТ-ийн гадаад мэдээний орчуулагч, редактор

Оршил

Их Британийн геополитикч Хэлфорд Жон Маккиндер \1861-1947\ анх 1904 онд геополитикийн шинжлэх ухаанд “Түүхэн газарзүйн тэнхлэг” хэмээх шинэ ойлголтыг гаргаж ирсэн байдаг. Энэ номлол аливаа улсын хувьд хамгийн ашигтай байршил төв байрлал болно гэсэн санааг дэвшүүлж, дэлхийн төвд Еврази оршдог гэдгийг нотолжээ. Улмаар Евразийн төвд “Зүрхэн газар буюу Heartland” оршдог гэсэн санааг гаргасан байдаг.

Зураг №1.Маккиндерын дэлхийн зүрхэн газар¹⁸⁴



Евразийн бүс нутагт ноёлох үзэл санаа, өрсөлдөөн ХХI зуун гарснаас хойш эрчимтэй сэргэж байна. Энэ өрсөлдөөнд манай хоёр хөрш хэдийнээ татагдан орсон ч одоогоор өөр өөрийн байр сууриа алсуур хүлээн зөвшөөрүүлэх бодлогыг баримталж, олон төсөл санаачилгыг тус бус нутагт хэрэгжүүлж байна. ОХУ-ын газарзүйн байрлал болон өмнөх нөлөөний хүрээ тус улсын геополитикийг Евразитай салшгүй холбож өгдөг. Энэ утгаараа *

¹⁸⁴Эх сурвалж: <http://www.britannica.com/place/heartland>

ОХУ Евразийн их гүрэн хэвээр үлдэхийг чармайдаг¹⁸⁵. Харин БНХАУ Евразийн улс орныг эрчим хүчний түүхий эдийн баялаг эх сурвалж хэмээн харж уг бүс нутагт хүчтэй нөлөөлөх сонирхолтой болов. Үүнд Хятадын өнөөгийн улс төр, эдийн засгийн хөгжил, чадавх ихээхэн боломжийг олгож байна.

Эдүгээ ОХУ болон БНХАУ харилцаа, хамтын ажиллагаагаа шинэ шатанд хөгжүүлэхийн зэрэгцээ Евразийн бүс нутгийн орон зайд нөлөөгөө бэхжүүлэх үүднээс өрсөлдөх мөн хамтын хүчээ нэгтгэх шаардлагатай болжээ. Үүний нэг илрэл Шанхайн Хамтын Ажиллагааны Байгууллага /цаашид ШХАБ гэх/ болно. Өнөөдөр Евразийн бүс нутагт ШХАБ, ТУХН, Евразийн Эдийн Засгийн Холбоо гэх байгууллага өргөжин, хөгжиж улс төр, эдийн засаг, аюулгүй байдал зэрэг олон салбарт үйл ажиллагаагаа эрчимжүүлэх төлөвтэй байна. Эдгээр байгууллагаас ШХАБ-ыг цаашид улс төр, геополитикийн түвшинд Орос, Хятадын дэг журмыг үүсгэх нөлөө бүхий байгууллага болно хэмээн олон улс харах боллоо.

Энэхүү өгүүлэлд Евразийн орон зайд нөлөөгөө хадгалах ОХУ болон БНХАУ-ын бодлого, чиг хандлага, Монгол Улс анхаарах асуудлын талаар санал дэвигүүлэхийг оролдоно.

Нэг. Евразид баримтлаж байгаа ОХУ-ын бодлого ба ШХАБ

Хүйтэн дайны дараах үе дуусаж, Өрнөд, Орос стратегийн шинэ зөрчилд шилжсэн юм. Евро-Атлантын тэлэлтийг тогтоон барих, АНУ-ын дэлхийд тэргүүлэх үүрэг оролцоог хумихыг Москва эрэлхийлэх болсон явдал дэлхийн тавцанд тэргүүлэгч гүрэн болох ОХУ-ын сонирхлыг нотолж байна хэмээн үзэж болно. Оросын судлаачид ч АНУ дэлхийн их гүрэн байх оргил үеэ өнгөрөөсөн, Пакс Американа тогтолцоо гарцаагүй уналтын үе рүүгээ шилжлээ хэмээн дүгнэх болжээ.

Төв Ази бол Оросын ашиг сонирхлын нөлөөний бүс төдийгүй тэнд Орос үндэстэн 5 сая гаруй хүн аж төрдөг. Төв Азийн орнууд буюу ШХАБ-ын гишүүн орнуудтай ОХУ нягт, ойр харилцаатай төдийгүй ТУХН-ийн хүрээнд ч нөлөөтэй тоглогч. Нөгөө талаар Москва Төв Азид байр сууриа бэхжүүлэх, АНУ-ын нөлөөг хязгаарлах зорилго агуулах төдийгүй энэ бүсийн улс оронтой улс төр, эдийн засгийн хувьд нэлээд ойртох болсон БНХАУ-ын ашиг сонирхлыг тэнцвэржүүлэх, хүчний тэнцвэрийг барих бодлогыг ШХАБ-ын хүрээнд баримтлаж байна.

¹⁸⁵ Хуучин ЗХУ-ын үед Москва хот Зүүн Европ, Дундад Азийг нэгтгэсэн хүчирхэг гүрний нийслэл байв. 1991 онд ЗХУ задарснаар Евразийн их гүрний байр сууриа алдсан юм.

ОХУ-ын хувьд Төв Азид хамгийн хүчтэй нөлөөлж чадах улс. Өөрөөр хэлбэл, цэрэг улс төр, эдийн засгийн хувьд Төв Азид шахалт үзүүлэх бүхий л арга хэрэгсэл бий. Төв Азийн орнуудын эдийн засгийн гол хөдөлгүүр болох аж үйлдвэрүүдийн ихэнх нь ОХУ-ынх байдаг учраас Оросгүйгээр тэд хөдлөх боломжгүй.¹⁸⁶ Төв Азийн улс орны газрын тос, байгалийн хийн хоолой, автозам, төмөр зам гээд бүхий л холбоо, дэд бүтэц Оросын нутгаар дайрдаг. Энэ нь ОХУ-д Төв Азийг хянах боломж, давуу талыг олгодог юм.

Гэвч сүүлийн хоёр жилд Оросын эдийн засаг хямарсан явдал Хятадад Төв Азид эдийн засгийн бодлогоо тайван хэрэгжүүлэх шинэ боломжийг өгч, Бээжин тус бүс нутагт эдийн засгаар халхавчилсан улс төрийн бодлогоо явуулж байна.

Хоёр. ШХАБ-ын үүсгэн байгуулагч гишүүн БНХАУ

XXI зууны дунд үе гэхэд БНХАУ эдийн засгийн үзүүлэлтээрээ дэлхийд тэргүүлэх зорилт тавьж, бүс нутгийн их гүрэн болохоор урагшилж байна. Евразийн бүс нутагт Америкийн нөлөөг хязгаарлахын тулд БНХАУ сүүлийн жилүүдэд Евразийн бүс нутагт геополитикийн холбоотон, эдийн засгийн шинэ боломж бололцоог эрэлхийлэх болсон юм.

Хятад улс ШХАБ-ын хүрээнд Төв Азийн улс орнуудтай эдийн засаг, улс төрийн харилцаагаа улам тэлэх хандлага ажиглагдаж байна. Гэвч БНХАУ энэ бүс нутагт нэлээд алгуур, зөөлөн хүчний бодлого барьдаг. Үүний шалтгаан нь Хятадын баруун хойд бүсэд Төв Азийн ард түмэнтэй угсаа гарвал, соёл нэгт Шинжанийн уйгарууд аж төрж байна. Тэд салан тусгаарлах хөдөлгөөн багагүй өрнүүлдэг тул энэ бүс нутаг эрсдэлтэй алхам хийхийг хүсэхгүй бололтой.

ШХАБ-ыг үүсгэн байгуулах, тэлэх бодлогоо эрчимжүүлэх БНХАУ-ын үзэл санаа ОХУ-ынхаас өөр. Тухайлбал, Төв Азиас цухалцах терроризм, хэт доворхох, салан тусгаарлах үйл ажиллагаа тус улсын үндэсний ашиг сонирхолд заналхийлэгч нэг хүчин зүйл хэмээн Бээжин үздэг. Түүнчлэн Хятадын хувьд Төв Ази бол бараа бүтээгдэхүүн, технологио нийлүүлэх эрэлттэй бүс нутаг төдийгүй эрчим хүчний эрэлтээ хангах эх үүсвэр болдог.

¹⁸⁶ How the Russia-China Strategic Partnership Marks a New Global Power Shift, by Pepe Escobar

[http:// www.altemet.org/world/how-russia-china-strategic-partnership-inarks-new-global-power-shift](http://www.altemet.org/world/how-russia-china-strategic-partnership-inarks-new-global-power-shift)

Тус бүс нутгийн хамтын ажиллагааг бэхжүүлэх явдал БНХАУ-ын аюулгүй байдлыг төдийгүй эдийн засгийн хөгжлийг хангах суваг болдог. Иймийн учир Төв Азид хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлэх, аюулгүй байдлаа бэхжүүлэхэд ШХАБ-ыг нэг төрлийн хөшүүрэг болгох зорилгоор ажиллаж байна.

Хятад улс ШХАБ-д элсэн орсноос хойших 20 жилд Төв Азийн орнууд болон ОХУ-ын хооронд итгэлцлийг бэхжүүлэхэд анхаарсан юм. Тухайлбал, Хятад, Төв Азийн хоорондын худалдаа 2000 онд 1 тэрбум ам.доллар байсан бол 2013 оны байдлаар 50 тэрбум америк долларт хүрч өсчээ. Ер нь Хятадын эдийн засгийн энэхүү хурдацтай тэлэлт Төв Ази дахь гадны тоглогчдын нөлөөний тэнцвэрийг өөрчилсөн юм. Хятад улс энэ хугацаанд Төв Азийн орнуудтай хөрөнгө оруулалт худалдаа, эрчим хүчний зэрэг тэргүүлэх салбарт олон арван шинэ гэрээ хэлэлцээр байгуулжээ.¹⁸⁷ Хятад улс Төв Ази дахь шинэ түншүүдтэйгээ нягт хамтрах, тэдний итгэлийг олоход худалдааны хамтын ажиллагааг амжилттай ашиглаж байна. Хятад улс Казахстанас газрын тос, байгалийн хий, уран, мөн Туркместан, Узбекистанаас байгалийн хий импортоор авдаг юм. Мөн Кыргызстан, Тажикстанд алтны уурхай ажиллуулахын зэрэгцээ Тажикстанд газрын ховор элемент олборлохоор судалгаа явуулж байна. Түүнчлэн Төв Азид авто зам, төмөр зам, байгалийн хий дамжуулах хоолой тавихад Бээжин санхүүжилт оруулж байна. Энэ бүхэн Төв Ази дахь Бээжингийн ашиг сонирхлыг байгалийн баялаг болохыг гэрчилж, үүнийгээ ШХАБ-ын хүрээнд хэрэгжүүлэх бүх суурь ажиллагааг явуулсан гэхэд болно.

Төв Азийн орнууд ч Хятадын эдгээр төслөөс тодорхой хэмжээний ашиг хүртдэг. Цаашид Төв Азийн орнууд Хятадыг Европтой холбох Хятадын Шинэ Торгоны Зам санаачилгаас ашиг хүртэх боломжтой. Гэхдээ Төв Азийн улс орон бүр Хятадын эдийн засгийн тэлэлтийг тийм ч таатай хүлээж авдаггүй. Тухайлбал, Казахстаны зарим иргэн, аж ахуй нэгж Хятадын хувийн салбар, бизнесийн үйл ажиллагаагаанд оролцохоос зайлсхийх хандлага сүүлийн жилүүдэд нэмэгджээ.

Гурав. ШХАБ-д баримтлах Монгол Улсын стратеги бодлого

Монгол Улс Зүүн Хойд Ази, Төв Азийн бүс нутгийн аль алинд нь хамрагдах газарзүйн онцлог байрлалтай. Эдгээр бүс нутагт өрнөж буй улс төр, эдийн засгийн олон талт хамтын ажиллагаанд идэвхтэй оролцохыг гадаад бодлогынхоо нэг чиглэл гэж үздэг. Иймд Монгол улс ШХАБ-ыг Төв Азийн

¹⁸⁷ Central Asia's Energy rush <http://thediplomat.com/2014/07/central-asias-enerny-rush>

бүс нутгийн олон талт хамтын ажиллагаанд оролцох чухал гарц хэмээн харж, 2004 онд тус байгууллагын анхны ажиглагч гишүүн болсон юм. Үүнээс хойш 13 дахь жилдээ ажиглагчийн байр сууриар идэвхтэй хамтран ажиллаж байна. Энэ хугацаанд Монгол Улс ШХАБ-ын гишүүн орнуудын төр засгийн тэргүүн нарын уулзалтад болон зарим салбарын сайд нарын уулзалт, ШХАБ-ын ажил хэргийн зөвлөл, ШХАБ-ын форумын үйл ажиллагаанд оролцож иржээ. Эдийн засгийн хамтын ажиллагаанд илүү ач холбогдол өгч байгаа ШХАБ-ын хүрээний Монгол Улс бүх түвшний арга хэмжээнд оролцох сонирхолтой гэдгээ ч илэрхийлж ирсэн юм.

Монгол Улс ШХАБ-ын гишүүн улс орнуудын хооронд худалдаа, эдийн засгийн олон талт хамтын ажиллагааг хөгжүүлэх хөтөлбөрийн хэрэгжилтэнд анхаарч, хамрагдах боломжийг судалж ирсний зэрэгцээ энэхүү хөтөлбөрүүдийг үндсэн гишүүн, ажиглагч, яриа хэлэлцээний түнш орнуудын оролцоотойгоор боловсруулан гаргах саналыг дэвшүүлсэн байдаг. Тухайлбал 2013 онд Узбекистаны нийслэл Ташкент хотноо болсон ШХАБ-ын гишүүн орнуудын засгийн газрын тэргүүн нарын зөвлөлийн хуралдаанд Монгол Улсын засгийн газрыг төлөөлж оролцсон Шадар сайд Д.Тэрбишдагва ШХАБ-ын үйл ажиллагаанд Монгол Улс идэвхтэй оролцохыг эрмэлзэж ирсэн бөгөөд худалдаа эдийн засгийн харилцан ашигтай хамтын ажиллагааг үйл ажиллагааныхаа үндсэн чиглэл болгож байгаад Монголын засгийн газар өндөр ач холбогдлол өгч ирснийг тэмдэглэсэн юм.¹⁸⁸ Үүний зэрэгцээ цаашид тус байгууллагын хүрээнд хэрэгжүүлэх бүс нутгийн томоохон төсөл, хамтын ажиллагаанд илүү идэвхтэй оролцох саналтай байгаагаа илэрхийлэхийн хамт Монгол улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх тээврийн салбарт хамтын ажиллагааг хөгжүүлэх сонирхолтой байгаагаа илэрхийлсэн юм.

Мөн 2015 онд ШХАБ-ын худалдаа, эдийн засгийн сайд нарын 14 дэх удаагийн уулзалтад Монгол Улсын аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбат оролцож, ШХАБ-ын үндсэн гишүүн болон ажиглагч улс орнуудтай боловсруулах аж үйлдвэр, эрчим хүч, дэд бүтэц, дамжин өнгөрөх тээврийн салбарт харилцан ашигтай, үр өгөөжтэй хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжиж, хамтын ажиллагааг хөгжүүлэхийг эрмэлзэж байгаагаа илэрхийлсэн байдаг.¹⁸⁹

Өнөөдрийн байдлаар ШХАБ-ын гишүүн орнуудын эдийн засаг дэлхийн ДНБ-ий 20 орчим хувийг эзэлж, тус интеграцийн эдийн засгийн чадавх нэмэгдэж байна. Дэлхийн хоёр том гүрнийг багтаасан эдийн засаг, улс

¹⁸⁸ <http://sonin.mn/news/politics-economy/22296>

¹⁸⁹ www.mfa.gov.mn

төр, аюулгүй байдлын томоохон механизм бий болох бололцоо байгаа ч ШХАБ-д саналын зөрүүтэй зарим асуудал одоо хэр оршсоор байгаа явдал энэ байгууллагын үйл ажиллагаа жигдрэхэд саад учруулж байна.

Монгол Улс ШХАБ-ын талаар маш тодорхой байр суурь баримталж байгаа. Тодруулбал, ШХАБ-ын хөгжил, ирээдүйн төлөвийг анхааралтай ажиглаж, харзнаж байна. Энэ нь юуны өмнө ШХАБ бүрэн төлөвшөөгүй, үйл ажиллагаа нь жигдрэх шатандаа яваа тул түүний хөгжлийн хандлагыг тодорхойлоход тодорхой цаг хугацаа хэрэгтэй байгаатай холбоотой. Нөлөө талаар тус байгууллагыг голчлон цэрэг, улс төрийн болон аюулгүй байдлын өнцөгөөс харах явдал бусад орны хувьд нэлээд түгээмэл байгаатай мөн уялдаж байж болно.¹⁹⁰

Эдүгээ ШХАБ-ыг өргөжүүлэх, шинэ гишүүн элсүүлэх тэр дундаа Монгол Улсыг элсүүлэх сонирхол хоёр хөршид бий. Монгол Улсыг ШХАБ-д орохыг шахах хоёр хөршийн зорилго алсуураа АНУ болон Өрнөдтэй харилцах ОХУ болон БНХАУ-ын бодлоготой холбоотой байж болзошгүй. Тухайлбал, 2014 оны 07 дугаар сард Хятадын гадаад хэргийн сайд Ван И Монгол Улсын Ерөнхий сайдаас ШХАБ-д бүрэн гишүүнчлэх талаар нааштай мэдээлэл авсан, тиймээс Монгол Улс ШХАБ-д гишүүнээр элсэж болзошгүй, энэ бол бидний хувьд сайны дохио¹⁹¹ гэсэн мэдэгдэл хийж байв.

ШХАБ-ын өнөөгийн хөгжлийн байдлаас харвал цаашид улс төр, аюулгүй байдлаас гадна эдийн засгийн хамтын ажиллагааг тэргүүлэх чиглэлийн нэг болгох төлөв харагдаж байна. Энэ байгууллагын хүрээнд хэлэлцэж байгаа чөлөөт худалдааны бүс, ачаа тээврийн зохицуулалт, хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдүүлэх, байгалийн гамшигтай хамтран тэмцэх, олон улсын терроризм, хил дамнасан гэмт хэрэг, хар тамхины наймааны эсрэг тэмцэх зэрэг асуудал манай улсын ашиг сонирхол, аюулгүй байдалтай зарим талаар зайлшгүй холбогддог.¹⁹² Иймд уг байгууллагыг онцгойлон анхаарах хэрэгтэй. Гэвч ШХАБ-д гипгүүнээр элсэх явдлыг манай “Гуравдагч хөрш”-үүд хэрхэн үнэлэх нь сонирхолтой асуудал юм.

Монгол Улс ШХАБ-д элссэн нөхцөлд эдийн засгийн тусламж дэмжлэг хүртэх боломж бий. Ялангуяа, нефтийн бараа бүтээгдэхүүний хараат байдлаас ангижрах, хоёр хөршийн эрчим хүч, тээврийн салбарын хамтын

¹⁹⁰Д.Мягмар, Аюулгүй байдлын судалгааны зарим асуудал, хуудас 34, 2014 он.

¹⁹¹ Will Mongolia Be The Next SCO Member? <http://www.eurasianet.org/node/69001>

¹⁹²Д.Мягмар, Аюулгүй байдлын судалгааны зарим асуудал, хуудас 35, 2014 он

ажиллагаанаас ашиг хүртэх зам харьцангуй нээлттэй болох юм. Гэвч нөгөө талаар ШХАБ-ын гишүүн болсноор АНУ тэргүүтэй Өрнөдийн орнуудтай хэрхэн харилцах явдал өнөөгийн олон улсын амьдралд өрнөж байгаа үйл явдалтай холбож үзвэл тун чиг ярвигтай хэрэг болно.

Дүгнэлт

Эдүгээ Евразийн их гүрэн ОХУ эргэн сэргэх замдаа орж, түүний үүрэг нөлөө Төв Азид хүчтэй боллоо. Үүний зэрэгцээ бүс нутагтаа аль хэдийн оройлж, дэлхийн их гүрэн зорилго тавиад байгаа манай өмнөд хөрш БНХАУ Төв Ази, цаашлаад Евразийн орон зайд нөлөөгөө бэхжүүлэх үүднээс улс төр, эдийн засгийн орчинд хэдийнээ байр сууриа эзлээд байна. Орос, Хятад хоёр эдийн засаг, улс төр, эрчим хүчний бодлогоо урагшлуулахын тулд бүс нутгийн хамтын ажиллагааны механизмыг өргөн ашиглах, хөшүүрэг хийх явдал улам эрчимжиж байна. Иймээс бүс нутагт хоёр хөршийн гүрнүүдийн геополитикийн ашиг сонирхол зөрчилдөх явдал Евразийн бүс нутгийн хамгийн эмзэг асуудал болно.

Хоёр хөршийн амин чухал бүс болох Төв Ази, түүний дотор ШХАБ-ын олон улсын харилцаанд эзлэх жин нөлөө улам өссөөр байна. ШХАБ-д Монгол Улс ажиглагчийн байр суурьтай хамтран ажиллаад 13 жил болж байна. Энэ хугацаанд Монгол Улс ШХАБ-ын үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, өөрийн байр суурь санал, санаачилгаа илэрхийлж ирсэн юм.

Эдүгээ ШХАБ-ын жин нөлөө дэлхийн улс төр, геополитикт улам бүр өсөн нэмэгдэхийн хэрээр ОХУ, БНХАУ-ын эдийн засаг, эрчим хүчний бодлого энэ байгууллагын хүрээнд өргөжих төлөвтэй байна. Хоёр хөршийн харилцаа таатай үед ирж, үүнийхээ нөлөөгөөр эдийн засаг, улс төрийн бодлогоо бүс нутгийн хамтын ажиллагааны байгууллага, холбоодоор дамжуулж явуулах хандлага тогтож байна. Үүний илрэл бол ШХАБ, ЕАЭЗХ, Бүс ба зам санаачилга, Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк зэрэг хоёр хөршийн оролцоотой байгууллагууд хамтран, хөгжих эхлэл аль хэдийн тавигджээ. Хоёр хөршийн стратегийн түшлэлд ойрын үед ан цав үүсэхээргүй байгаа тул эдгээр механизм хамтран хөгжих үндэстэй болно. Хоёр хөршийн хамтдаа урагшлах, дэлхийн их гүрэн болох холыг харсан бодлого, тэмүүлэлд орчин үеийн олон улсын харилцааны тулгамдсан асуудал ялангуяа газрын тосны ханшийн уналт, Ойрх Дорнодын хямрал эерэгээр нөлөөлж байна. Өөрөөр хэлбэл, эдгээр сорилт бэрхшээлийг хоёр хөрш боломж, гарц зарим тохиолдолд хөшүүрэг болгон ашиглах стратеги баримтлаж байна.

Нэг үгээр бол нэг нь нөгөөгөө нөхөх стратеги одоогоор хоёр хөршийн улс төр, эдийн засгийн салбарт үйлчилж, энэ нь ч үр дүнгээ өгөх боллоо. Ийм нөхцөлд хоёр хөршийн дунд стратегийн чухал байршилд орших Монгол Улсад хөгжлийнхөө хурдыг тэлэх боломж, мөн сорилтын аль аль нь тулгарч байна.

Монгол Улсын аюулгүй байдал болон гадаад бодлогын тулгуур баримт бичигт заасанчлан хоёр хөрштэйгөө эн тэнцүү харилцах гадаад бодлогын тэргүүлэх чиглэлээ баримтлахын сацуу ардчилал, улс төрийн бие даасан байдлаа хангах үүднээс “Туравдагч хөрш”-ийн бодлогоо буцалтгүй хөгжүүлэх явдал Монгол Улсын язгуур эрх ашигт шууд нийцнэ хэмээн үзнэ.